

## МОНГОЛ ДАХЬ ТҮРЭГ СУДЛАЛ

*Б.Мандхай\**

Монгол Улсын нутаг дэвсгэр бол зөвхөн монголчуудын төдийгүй, дэлхий дахины түүх, соёл иргэншилд зохих нөлөө үзүүлдсээр ирсэн төв Азийн нүүдэлчдийн соёлын дурсгалт зүйлийн өлгий нутаг мөн болохыг судлаачид анхааран үзэхийн зэрэгцээ, бусад орны ард түмний түүхийг судлахад Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгалууд чухал эх сурвалж болохыг нягтлан тогтоосоор ирсэн байна. Эдгээр үнэт дурсгалуудын цөөнгүй хувь нь түргийн үед холбогддог билээ.

Манай оронд сүүлийн жилүүдэд олон зуун жилийн түүхтэй Түрэг, Монголын ард түмний уламжлалт харилцааг сэргээн хөгжүүлэх таатай боломж нээгдэж Турк, Казах, Узбек, Кыргыз, Азербайжан, Туркмен улс болон ОХУ-ын Тува, Саха улстай тогтоосон харилцаа хамтын ажиллагаа улам бүр гүнзгийрэн хөгжиж байна.

Үүний жишээ нь түрэг угсаатаны нэг болох Турк улс бөгөөд Бүгд найрамдах Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд 1969 оны 10 сарын 24-ний өдөр албан ёсоор дипломат харилцаа тогтоосон билээ. Манай улстай дипломат харилцаа тогтоосон 41 дэх улс болсон юм. Гэвч тухайн үед дэлхий ертөнцөд ноёрхож байсан “Хүйтэн дайн”-ы нөлөөгөөр эсрэг бусад улсуудын нэгэн адил тэр бүр хөгжилгүй зогсонги байдалтай байсаар ирсэн юм.

Турк улс судлалыг өрнийн улс орнуудын нэгэн адил ерөнхий гурван үе шат болгон хуваан авч үзэж болно. Үүнд 1. Эртний харилцаа буюу эрт цагаас 1969 он хүртэл, 2. “Хүйтэн дайн” үзэл сурталт нийгмийн үе (1969-1990 он) 3. Шинэ үеийн харилцаа буюу (1990 оноос өнөөг хүртлэх үе) гэж үзэж болох юм.

Эрт үеийн харилцааны түүх харьцангуйгаар нилээд нарийн судлагдсан. Харин сүүлийн үед шинэ үеийн харилцааны түүхийг сонирхон судлах судлаачид цөөнгүй ном бүтээл гаргаж байна.

1990 оноос хойших хугацаанд хоёр улсын хоорондын хамтын ажиллагаа, төр, засгийн өндөр дээд хэмжээний айлчлал олноор хийгдэж Монголын мусульман нийгэмлэгийн төлөөлөгчид 1991 онд эхлэн Турк улсад айлчилж тус улсын Шашны хэрэг эрхлэх Яам, Соёлын Яамны сайд нартай болон бусад хүмүүстэй уулзаж харилцаа тогтоож байжээ. Тус нийгэмлэгийн шугамаар Туркт 1993 оны байдлаар шашны болон бусад сургуульд 150 орчим хүүхэд төрөл бүрийн мэргэжлээр сурч эхэлжээ. 1995 оны байдлаар Туркийн их, дээд сургуульд Монголын 89 оюутан шашны шугамаар суралцаж байв.

\* Б.Мандхай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Мөн Монгол Улсын томоохон хот, аймгууд болох Улаанбаатар, Дархан, Баян-Өлгий зэрэг газруудад Турк лицей сургуулиуд нээж олон тооны сурагчид суралцаж, Монголын цэргийн албан хаагчдыг Туркийн цэргийн сургууль, дамжаанд суралцуулж эхлэх хоёр улсын Засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу энэ мэт цөөнгүй оюутан, сурагчид, боловсон хүчнээ суралцуулж, туршлага солилцон эзэмшүүлэх болон бусад олон арга хэмжээ тус улстай холбоотойгоор явагдаж байна. Энэ байдал нь турк судлалыг баруун болон төв Азийн бусад улсуудын судалсан байдалтай харьцуулахад төдийлөн бага ч сүүлийн жилүүдэд эрчимтэй тэлж эхлээд байна. Тухайлбал “түрэг буюу турк-монгол” судлалын төвийг Монгол Улсад хөгжүүлэх, шинэ залуу, боловсон хүчин бэлтгэх зорилгоор МУИС-ийн захирлын тушаалаар 2000 оны 11-р сард Монгол хэл соёлын сургуулийн харьяанд Түрэг судлалын төв байгуулах шийдвэр гарч 2001 оны хичээлийн жилээс тус төвийн үйл ажиллагаа эхлэн явагдаж, түрэг судлалын өнөөгийн хандлага, сургалтын чиглэлээс үүдэн 2006 оны хичээлийн жилээс МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуульд шилжин иржээ.

Түрэг судлалын төв /тэнхим/-ийн үйл ажиллагаа нь:

1. Эрдэм шинжилгээ, судалгаа

2. Сургалт: а. Тэнхимийн сургалт, б. Хээрийн дадлага

3. Гадаад харилцаа гэсэн гурван үндсэн чиглэлтэй ажилладаг бөгөөд судалгаа, шинжилгээгээ Монгол нутаг дахь түүх-археологи, угсаатны зүй, эртний үсэг бичгийн дурсгал, хадны зураг, тамга тэмдгийн зүйл, нэн ялангуяа эртний түрэг, уйгурын үсэг бичиг, хэл соёл, түүхийн судлал болон орчин цагийн турк хэлний чиглэлээр судалгаа хийж, урт, богино хугацааны хээрийн шинжилгээ, судалгаа, төсөл хэрэгжүүлэхийн зэрэгцээ оюутан залуу судлаачдын дунд “Түрэг судлал” сэдвээр олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал тогтмол зохион байгуулдаг уламжлалтай болов.

- Эртний түрэг, уйгурын үсэг бичиг, хэлний судалгаа

- Эртний түрэг, уйгурын түүх, археологийн судалгаа

- Монгол, түрэг хэлний харьцуулсан судалгаа

- Түрэг угсаат ард түмнүүдийн түүх

- Түрэг төрөл хэлнүүд

- Туркийн улс төр, эдийн засаг газар зүй

- Араб хэл

- Орчин цагийн турк хэлний судалгаа зэрэг үндсэн чиглэлүүдээрээр

Монгол дахь түрэг судлалыг өргөжүүлэн хөгжүүлж байна.

Мөн 2006 оноос ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэнгийн Европ судлалын тасагт турк-судлал хэмээх шинэ салбар бий болгосон нь Турк орон судлалыг түүхүү судлахад чиглэгдсэн байна. Тухайлбал тус хүрээлэнгээс улирал бүр гаргадаг “Олон улс судлал”-сэтгүүлд 2007 оноос эхлэн дугаар бүрт БНТУ-ын тухай танилцуулга, харилцаа хамтын ажиллагааны товч тойм,

манай хоёр улсын хоорондын харилцааны шинэ үеийг харуулсан өгүүлэлүүд гарсаар байна. Мөн тус хүрээлэнгээс эмхлэн гаргасан “Европийн холбоо ба хөгжлийн албан ёсны тусламж, үр өгөөж” хэмээх хамтын бүтээлд тус улсын талаар холбогдох материал нийтлүүлж судалгааны эргэлтэнд оруулж эхлээд байна. Цаашид ч тус улсын талаар бид бүгдийн анхаарлыг татсан зүйлсийг үргэлжлүүлэн судлах нь тодорхой юм.

Монгол улсад түрэг судлалыг үүсгэн хөгжүүлэхэд академич Б.Ринчен, академич Л.Болд, доктор профессор Н.Сэр-Оджав, доктор /Ph.D/ С.Харжубай, доктор /Ph.D/ М.Шинэхүү, доктор /Sc.D/ Д.Баяр, доктор /Sc.D/ М.Хурметхан, докторант Н.Гэрэлмаа нарын зэрэг эрдэмтэн эртний түрэг судлал, орчин цагийн түрэг хэлтэй ард түмний хэл, түүх, соёл, этнологи, угсаатны зүй, сурган хүмүүжүүлэх ухаан, аман болон бичгийн зохиол, археологи, эдийн засаг, хөгжим судлал зэрэг шинжлэх ухааны төрөл бүрийн салбараар бичиж туурвисан бүтээлүүд нь Монгол Улсын нийгмийн шинжлэх ухааны дунд хүндтэй байр эзлэн, түрэг судлалын шинжлэх ухаанд манай эрдэмтдийн оруулсан жинтэй хувь нэмэр хэмээн дүгнэн үзэх үндэстэй юм.

1990-ээд оноос хойш манай улсын гадаад харилцаа өргөжин тэлж дэлхийн олон улс оронтой харилцах болж, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх болсон билээ. Үүний үр дүнд БНТУ-тай харилцаа холбоогоо шинээр эхлүүлэн олон талаар хамтран ажиллах болжээ. Монгол хийгээд Турк улсын хамтын ажиллагаа өргөжихийн хирээр Монгол дахь түрэг судлалын цар хүрээ ч тэлж олон салбарыг хамрах болсон байна. Монгол дахь түрэг судлалын эхэн үед зөвхөн түүх, үсэг бичиг, соёлын талаархи судалгаа шинжилгээ түлхүү хийгдэж ирсэн тул өнөөгийн Турк орон судлал харьцангуй эхлэлийн шинжтэй байгаа гэж үзэж болно. Даяаршлын эрин үе дэх Ази Европийг холбосон Монгол, Туркийн урт хугацааны түүхэн харилцаа холбоо улам өргөжиж, Монгол дахь түрэг судлал гүнзгийрэн хөгжиж байгааг онцлон тэмдэглэхийн хамт Монгол дахь түрэг судлалын талаар товчхон танилцуулъя.

1935 онд Судар бичгийн хүрээлэнгээс Монгол нутаг дахь түрэгийн үеийн түрэг хэлтэн ард түмний соёлын хосгүй дурсгал болох Орхоны Хөшөө Цайдам дахь Күл-Тегин, Билгэ хаан, Тоньюкук, Моюунчур, Кули-чур, Тариатын түрэг бичээс Түрэгийн Билгэ хаан Күл-Тегин болон Налайхын Тоньюкугийн хөшөө дурсгалууд дээр хамгаалалтын хашаа саравч барьж, тусгай хүнд цалин өгч сахиулан хамгаалалтанд авч байжээ.

Эрдэмтэн Н.Сэр-Оджав 1970-аад онд, олон жилийн судалгаа шинжилгээнийхээ ажлын үр дүнгээр Түрэгийн археологийн дурсгал, түрэгийн түүхийн тоймыг харуулсан “Эртний түрэгүүд” сэдэвт бүтээлээ гаргажээ.

Н.Сэр-Оджав сурвалж бичиг, судалгааны зохиолыг ашиглахын хамт гол төлөв археологийн олдворт тулгуурлан “Монголын эртний түүх” бүтээлээ 1977 онд нийтлүүлэв. Неолитийн болон хүрэл зэвсгийн олдворууд,

дөрвөлжин булш, Чандманий соёлд тодорхойлолт өгч, хүрлийн үеийн аж ахуй, морь унаа, хүрэл цутгамал ба эд боловсруулах ажил, шүтлэг бишрэл, оршуулах зан үйл, нийгмийн байгууллын асуудлыг шинжилжээ. Түрэгийн түрүү үеийн түүхийг авч үзэхдээ Монгол, Скифийн холбоо, ялангуяа амьтны загварт урлагийн асуудал, түүнчлэн Хүннүгийн түүх, Ноён уулын соёл, Хүннү ба Өрнө дахины хэлхээ холбооны асуудлыг шинжилсэн байна. Зохиолд Монгол орны түүхийн зангилаа асуудлыг бас судалжээ. Феодализм бүрэлдэн тогтох үйл явц Жужаны үеэс эхэлж XIII зууны эхэн үед дууссан хэмээх дүгнэлтэд зохиогч хүрчээ. Н.Сэр-Оджавын энэхүү бүтээл нь Монголын эртний түүхийн гол асуудлуудыг цаашид судлан шинжлэх ажлын эх суурийг тавьсан гэж үздэг.

Гэвч манай улсын эртний түүхтэй холбогдолтой бөгөөд шинжлэх ухаанд мэдэгдээгүй дурсгалын зүйлс цөөнгүй байна гэж тэмдэглэгдсэн байдаг. Мөн доктор Н.Сэр-Оджав “БНМАУ-д түрэг бичгийн дурсгалыг судалж байгаа нь” гэдэг өгүүлэл бичиж, энэ салбарт 1960-аад он хүртэл олсон ололтыг нэгтгэн дүгнэсэн байна. Энэ бүтээлдээ манай оронд буй хорин хоёр түрэг бичээсний гэрэл зургийг нийтлүүлжээ.

Дэлхий дахинд эртний түрэгүүдийн бичиг үсэг болох руни бичгийг тайлан унших түлхүүрийг Зөвлөлт Оросын судлаач эрдэмтэн В.Томсен, В.В.Радлов нар нээсэнээс хойш дэлхийн олон орны эрдэмтэд уг бичээсүүдийг унших, орчуулах зэргээр нарийвчлан судалж байна. Монголд эртний түрэг бичгийн дурсгалыг судлах ажил 1950-аад оны үеэс зохион байгуулалттай эхэлсэн юм. Энэ завсар Монголын эрдэмтэд түүх дурсгалын хайгуул шинжилгээг өргөн явуулж, руни бичгийн сан хөмрөгийг шинэ шинэ олдвороор улам бүр баяжуулж, тэдгээрийн тухай мэдээлэх, хэвлэн, нийтлэх, тайлан унших, хооронд нь харьцуулах зэргээр эртний түрэг судлалыг хөгжүүлсээр ирвэ.

Эрдэмтэн М.Шинэхүү 1975 онд “Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал”, 1979 онд “Орхон Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал” зэрэг нэг сэдэвт бүтээлүүдийг хэвлүүлж улмаар Архангай аймгийн Тариат сумын Долоон модноос олдсон руни бичгийн хуулга эхийг хийж, түүнийг уншиж тайлахад эхний бүтээлээ зориулсан бол дараагийн бүтээлдээ Тариат, Хар балгас, Тэсийн голын руни бичгийн дурсгалуудыг нарийвчлан судласан байна. Мөн эрдэмтэн Л.Болд 1990 онд Монгол нутагас олдсон руни бичгийн дурсгалуудыг нэгтгэж “Монгол нутаг дахь хадны бичээс” бүтээлийг нийтлүүлжээ. Эдгээр эрдэмтдийн өгүүлүүд хэвлэгдэн гарсан нь Монгол дахь Түрэг судлалд ихээхэн ахиц гарч, тодорхой амжилтанд хүрсэн гэж хэлж болно.

Эртний түрэгийн үед цэцэн Тоньюжук /646-732/ хэмээн алдаршсан хүн өөртөө зориулан босгосон хөшөөний үг, Могилян хаан /683-734/, хун тайж Күл-Тегин /684-731/-д зориулан 732 онд босгосон хөшөөнд сийлсэн үгийг академич Б.Ринчен орос, монгол хэлнээ орчуулсныг түүхч Амар “Монголын товч түүх” хэмээх /1924 он/ номд нийтлүүлсэн байна.

1956-1957 онд Архангай аймагт явсан археологийн шинжилгээний ангийхан Тариат сумын нутгаас хожим “Тариатын түрэг бичээс” гэж алдаршсан бичээсийн доод хэсгийг, мөн “Бугатын бичээс”-ийг олжээ. 1956 онд А.Лувсандэндэв монгол улсын төв номын санд байсан түрэг бичээс, Х.Пэрлээ Архангай аймгийн Тайхар чулууны зарим түрэг бичээсийг судлан 1957 онд Тоньюкукийн булшны шаваасан бичээсийг Н.Сэр-Оджав олж С.Харжаубай тайлан уншсан, мөн Дундговь аймгийн орон нутаг судлах музейд хадгалагдаж байсан түрэг бичээсийг Х.Лувсанбалдан хэвлүүлснийг Б.Базылхан тайлан уншиж нийтийн хүртээл болгожээ.

1960-аад онд манай улсын нутаг дэвсгэр дэх эртний түрэг бичгийн дурсгалыг эрэн сурвалжлах “Дурсгалт бичгийн чуулган” гэдэг цувралын 1968 оны дугаарыг тус улсын нутагт буй хадны бичиг, гэрэлт хөшөөний зүйлд зориулан гаргажээ.

Урьд өмнө судалгааны эргэлтэд оруулсан боловч олоход бэрх болсон бичээс, Тэсийн түрэг бичээс, Күл-Тегиний хөшөөний мэлхий чулуун суурь дээрх түрэг бичээс, Өвөр дөрвөлжиний түрэг бичээс зэргийн гэрэл зургийг анх удаа энд нийтэлжээ. Энэ утгаараа уг бүтээл эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой юм. Энэ бүтээлд нийтлэгдсэн Хангидайн хад, Өвөр Дөрвөлжин, Гурвалжин уулын түрэг бичээс болон мөн бусад олон түрэг бичээсийг Б.Базылхан уншиж тайлбарласан байна. Тэрээр “Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтэц” гэдэг ганц сэдэвт зохиолдоо түрэг монгол судлаач нараас эртний түрэг бичгийн хэл ба монгол бичгийн хэлний үг зүйг судлахдаа саяхныг болтол ажиглаагүй нэгэн зүйл болох эртний түрэг хэл ба монгол бичгийн хэлний бүтцийг нарийвчлан судалж мөн алтай хэл шинжлэлийг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд онол арга зүйн хувьд хувь нэмрээ оруулжээ. Б.Базылхан өөрийн судалгааны бүтээлүүдээ монгол, түрэг хэлнүүдийн язгуур үгийн бүтцийг орчин бүтэц-хэл шинжлэл, уламжлалт түүхэн харьцуулсан хэл шинжлэлийн аль алины онол арга зүйг хослон ашиглаж, тэдгээр онол, арга зүйг боловсронгуй болгон, судалгаандаа чадамгай ашиглажээ. Тэрээр монгол, түрэг хэлүүдийн язгуур морфем нь “Ү”, “СҮ”, гэсэн бүтэцтэй, залгавар морфем нь “Ү”, “С”, “СҮ” гэсэн бүтэцтэй болохыг “Эртний түрэг бичээсийн хэлний үгийн бүтэц”, “Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулал” зэрэг судалгаандаа нотлон тогтоожээ.

Эртний түрэг бичээсийг сурвалжлан олох, судлахад Монгол-Зөвлөлтийн хамтарсан шинжилгээний анги чухал үүрэг гүйцэтгэж байв. 1969 оноос хойш уг шинжилгээний анги эрэл хайгуулын ажлыг төлөвлөгөөтэйгөөр гүйцэтгэж “Тариатын Түрэг бичээс”-ийн зарим хэсгийг нөхөн олж, Архангай аймгийн Хотонт сумын нутгаас Карабалгасуны түрэг бичээс, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын нутгаас Тэсийн түрэг бичээс зэргийг олж, Бигэр, Дарви, Цэнхэрмандал, Хутуг уул, Хангидын хад, Тэс,

Архангайн түрэгийн бичээсийг дахин нягтлан үзэж, судалгааны ажлын үр дүнгээсээ нийтэлжээ.

Эдгээр олон талт ажлын үр дүнд судалгаа шинжилгээний арга барил ч сайжирч 1970-аад оноос түрэг судлал нь бие даасан салбар болон хөгжих нөхцөл бүрдсэн байна. Түрэг судлаачдын бүтээл туурвил нь “Хэл зохиол”, “Монголын судлал”, “Түүхийн судлал”, “Археологийн судлал” цувралуудад хэвлэгдэх болжээ. Үүний зэрэгцээ доктор Н.Сэр-Оджавын “Эртний түрэгүүд” /VI-VIII зуун/ хэмээх ном гарсан юм. Зохиогч уг номдоо 1970-аад он хүртлэх тус улсын нутгаас олдсон хэрэглэгдэхүүнийг судлан эрдэм шинжилгээний талаар ангилан цэгцэлж газар зүйн байдлыг тогтоосны зэрэгцээ түрэгийн эдийн ба оюуны боловсрол, төрийн түүхэн холбогдол бүхий олон асуудалд хариу өгчээ.

Мөн М.Шинэхүү Тариатын гэрэлт хөшөөний бичгийг тайлан уншаад хөшөөний үгийг утгын талаас нь ангилж үзжээ. Энэ нь хэлний харьцуулсан судлалд чухал ач холбогдолтой болсон төдийгүй эртний түрэг бичгийг сонгодог монгол бичгийн хэлтэй харьцуулсан явдал байв. М.Шинэхүү мөн “Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал” гэдэг ганц сэдэвт зохиол бичиж хэвлүүлсэн юм.

1970-аад оноос руни бичгийн судалгаа хөгжиж А.Лувсандэндэв, М.Шинэхүү, Б.Базылхан, Л.Болд, С.Харжаубай, Ц.Баттулга нарын эрдэмтэд шинээр олдсон гэрэлт хөшөө болоод бага бичээсийн дурсгалыг тайлан унших, өмнөх судалгааг нягтлах зэрэг судалгааны ажил хийжээ.

Академич Л.Болд “БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс” хэмээх номондоо тус улсын нутаг дэвсгэрт буй түрэг бичээсийг судалсан байдал, гол судалгаануудад тулгуурлан нилээд бичээсийн утгын орчуулгыг тоймлон оруулсан нь тус салбарын дорвитой ололтын нэг болов.

Манай түрэг судлаачид хөшөөний бичгийг монгол хэл, орчин цагийн утга зохиолын хэлээр орчуулаад зогсохгүй эртний түрэг бичгийн дурсгалын үгийн сан, үг зүйг тусгайлан судлах чимхлүүр ажлуудыг хийж байна. 1970-1980 онуудад түрэг судлаачид эрдэм шинжилгээний томилолт, шинжилгээний ангиар явж, хадны бичээсүүдийг эрэн сурвалжлах, тайлан унших, орчуулах, тухайлбал Орюн хааны түрэг бичээс, Билгэ хаан, мэргэн Тонюкукын хөшөөний бичээс зэрэг олдворуудыг олон нийтэд мэдээлэх ажлыг үргэлжлүүлэн хийж буй дорвитой ажил бол “Монгол Улсын нутаг дахь түрэг бичгийн атлас”-ыг зохиож хэвлэлд нийтлүүлж судалгааны эргэлтэнд оруулсан явдал юм.

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Шинэхүү. “Бигэрийн түрэг бичээс”. УБ. 1971, “Дарвийн түрэг бичээс” УБ. 1972. “Хангидайн хадны түрэг бичээсийг дахин нягталсан нь” УБ. 1979.
2. Х.Пэрлээ. “Тайхар чулуу” УБ. 1960.
3. Н.Сэр-Оджав. “Шинээр олдсон түрэг бичээсийн тухай” УБ. 1960.
4. Б.Базылхан. “Күл-Тегиний хөшөөний мэлхий чулууны түрэг бичээс” УБ. 1979.
5. Б.Ринчин. “Монгол нутаг дахь хадны бичээс гэрэлт хөшөөний зүйл” УБ. 1968.
6. С.Харжаубай. “Тэсийн гэрэлт хөшөө”. УБ. 1979.
7. Л.Болд. “БНМАУ-ын эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал”
8. М.Хурметхан. “Монгол Улс дахь түрэг судлалын тойм” Дорно өрнө сэтгүүл УБ. 1994. №1
9. Ц.Баттулга. “Монголын руни бичгийн бага дурсгалууд” УБ. 2005.